

МОНГОЛ ОРООНД ХОТГУУЖИН ЧӨРХИЙН *Histrionicus histrionicus* ХОЁР ДАХЬ ТОХИОЛДОЛ ТЭМДЭГЛЭГДЭВ

Баатаргалын Отгонбаяр¹, Суурийн Баяндэлгэр², Бадамжавын Лхагвасүрэн³

^{1,3}Хөхтний экологийн лаборатори, Ерөнхий болон Сорилын Биологийн хүрээлэн, Энхтайвны өргөн чөлөө 54Б, Улаанбаатар 210351

²Биологийн тэнхим, МУИС-ийн Байгалийн ухааны сургууль, Их сургуулийн гудамж I, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 210646

харилцах хаяг: otgonbayar.1025@gmail.com

хураангуй. 2016 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Дорнод Монголд ажиллаж явахдаа Дашибалбар сумын Хайрханы цагаан нууранд нэг хос хотгуужин чөрхтэй таарсан. Энэ зүйлийн хувьд Монгол орны хувьд хоёр дахь удаагийн тохиолдол бөгөөд анхны фото зурган баримт болж байна.

тулхүүр үе: хотгуужин чөрх, *Histrionicus histrionicus*, ховор зүйл

abstract. During a field survey to eastern Mongolia, we photographed a pair of Harlequin duck on 8th of May 2016 at Hairkhan Tsagaan lake in Dashbalbar soum, Dornod Province. This is the second record of this species for Mongolia and the first photographic record.

keywords: Harlequin duck, *Histrionicus histrionicus*, rare records

Тоодог 2:44-45, 2016

Бид саарал чоно болон цагаан зээрийн судалгааг 2016 оны 5 дугаар сарын 4-нөөс 12-ны хугацаанд Монгол орны зүүн аймгуудын нутгаар хийж гүйцэтгэх явцдаа сонирхолын дагуу гол, нуур, ус намгархаг газаруудад нүүдлийн шувуудыг давхар ажиглан зураг авч тэмдэглэл хөтөлсөн ба тэдгээрийн нэг нь Дорнод аймгийн Дашибалар болон Баяндун сумдын нутгийн заагт орших Хайрхан Цагаан нуур ($N 49.36088^{\circ}$, $E 113.59104^{\circ}$) байв. Бид 5-р сарын 8 ны өдөр уг нуурын хажууд түр буудаллаж ажиглалт хийсэн. Нууранд 3 эр сэвгэр бохио *Mergus serrator*, 4 эм цахиур бохио *Mergus albellus*, болон ногоохон нугас, халбага нугас зэрэг хэд хэдэн зүйлийн усны шувууд байв. Тэдгээрээс гадна нэг хос хотуужин чөрх *Histrionicus histrionicus* байхыг олж харсан. Энэхүү шувуу нь Монгол оронд түгээмэл тохиолдох нугаснаас өнгө зүсний хувьд тод ялгарах тул баталгаажуулан зургийг нь авлаа. Уг нугас нуурын зүүн урд байсан ба биднийг дөхөж ойртуулахгүй байсан. Өмнө нь хотуужин чөрхийг 1962 оны 6 сарын 1-2 нд Баянхонгор аймгийн Богд сумын нутагт орших Орог нууранд ганц шувуу ажигласан мэдээ байдаг (Fischer 1970).

Жижиг нугасны тоонд ордог энэ зүйлийн биеийн урт 38-45 см, далавчны дэлхэц 63-70 см

хүрнэ (Brazil 2009). Хотгуужин чөрх нь богино хошуу, өндөр дух, бүдүүн хүзүү, үзүүрлүүгээ нарийссан сүүл зэргээрээ бусад нугаснаас ялгарна. Эр шувууны биеийн хажуу болон толгойн орой хэсэг хүрэн, бусад хэсэг нь хөх саарал өнгөтэй. Хацар, дух, чих, хүзүү, цээж, нурууны цагаан толбууд нь түүнийг өвөрмөц төрхтэй харагдуулдаг. Эм шувууны толгой хүзүү нь бараан саарал ба бие нь гэдэснээс бусад хэсгээрээ бараан бор, нүүр болон чихний ард дугуй цагаан толботой.

Уг нугас нь Хойд Америкийн баруун хойд, зүүн хойд хэсгээр, Оросын зүүн хэсэг, Алеутын арлууд, Гренландийн өмнөд хэсгээр мөн Исландад тархана. Харин өвлүүн улиралд хол нүүдэллэх ба Солонгос, хойд Калифорния болон хойд Каролина хүрнэ. Уржлийн үедээ уулын түргэн урсгалтай гол горхинд их тохиолдог ба өвлүүн улиралд бол чулуурхаг эргийн дагуу өвөлждөг (del Hoyo *et al.* 1992). Монгол орны хувьд хотгуужин чөрх нь дамжин өнгөрдөг буюу тохиолдох зүйл юм.

Хотгуужин чөрх нь олон улсын хэмжээнд анхааралд өртхөөргүй ангилалд хамрагддаг (BirdLife International, 2015) бол бус нутгийн хэмжээнд үнэлэх боломжгүй гэж ангилагдсан байдаг (Gombobaatar and Monks, 2011).



Ашигласан бүтээл

Birdlife International. 2016. Species factsheet: *Histrionicus histrionicus*. Downloaded from <http://www.birdlife.org> on 13/5/2016

Brazil, M. 2009. Birds of East Asia: eastern China, Taiwan, Korea, Japan, eastern Russia. Princeton University Press, London.

Fischer, W. 1970. Ornithological observations and an attempted bird survey at the Mongolian desert lakes, Orog and Buuntsagaan. Zool. Abh. Ber. Mus. Tierkd. 30:101-129. (in German)

Gombobaatar, S. & Monks, E. M. eds. 2011. Mongolian red list of birds. Regional red list Series, Vol. 7. Zoological Society of London & National University of Mongolia & Mongolian Ornithological Society.

del Hoyo, J.; Elliot, A.; Sargatal, J. 1992. *Handbook of the Birds of the World*, vol. 1: *Ostrich to Ducks*. Lynx Edicions, Barcelona, Spain

